



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 36

Алтай

Говь-Алтай аймгийн түүхийн
он, тооллыг сэргээн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Ардын Сайд нарын Зөвлөлийн 1923 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бидний Алтайн түүх" эрдэм шинжилгээний хуралд илтгэгчдээс ирүүлсэн санал, түүх, архивын баримтыг хэлэлцээд Засагт хан аймаг байгуулагдсан 1558 он, "Хантайшир уулын аймаг" 1923 онд байгуулагдсаны үргэлжлэл гал голомт Говь-Алтай аймаг тул аймгийн түүхийг тухайн он жилээс эхлэн тоолохоор тогтоосугай.

2. Засагт хан аймаг байгуулагдсаны түүхэн 460 жилийн ой, Хантайшир уулын аймаг буюу одоогийн Говь-Алтай аймаг байгуулагдсаны 95 жилийн ойг 2018 онд тэмдэглэсүгэй.

3. Засагт хан, Говь-Алтай аймгийн түүхийг сэргээн тогтоосныг сурталчилах ажлыг өргөн хүрээнд өрнүүлж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ДЭЛГЭРЖАРГАЛ



/My doc/ Blank-ITH togtool

02 000035